



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 590

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 23,000,000.00 /хорин гурван сая/ төгрөгийн балансын үнэ, 15,716,666.67 /арван таван сая долоон зуун арван долоон мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн балансад шилжүүлсүгэй.

2. “Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Цэдэнбал, “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001158

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
590 дугаар тогтоолын хавсралт



"Увс АЗЗА" төрийн өмчит хувьцаат компаниас "Архангай АЗЗА"
төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад
шилжүүлэх автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглагдах орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Лексус-470, 81-81 УВХ, арал № JTJHT00W743 543426	2004/ 2008	23,000,000.00	15,716,666.67	7,283,333.33
	Нийт дүн		23,000,000.00 /хорин гурван сая/	15,716,666.67 /арван таван сая долоон зуун арван долоон мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө/	7,283,333.33 /долоон сая хоёр зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө/